

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2026/038/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ӨНДӨРШИРЭЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Зуунмод 2026 он

Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Б.Нямсүрэн

Утас: 70272248 Цахим хаяг: nyamsurenb@audit.gov.mn



Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМГИЙН ӨНДӨРШИРЭЭТ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Г.ЦЭЦЭГМАА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн Б/04 дүгээр захирамжаар Засаг даргын Тамгын газрын бүтэц орон тоог удирдах 3, төрийн жинхэнэ албаны гүйцэтгэх 8, төрийн үйлчилгээний гүйцэтгэх 3, гэрээт буюу туслах чиг үүргийн 4 албан тушаалтан, улс төрийн буюу багийн Засаг дарга 4, нийт 22 орон тоотой батлагдсанаас бүтэц орон тоог шинэчлэн 26 орон тоотойгоор баталж, гүйцэтгэлээр 25 орон тоотой ажилласан байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд ЗДТГ-ын шилжих үлдэгдлийн хөрөнгөөр ахуйн үйлчилгээний засварын ажлын урьдчилгаа 70 хувь болох 34,607.0 мянган төгрөг, тэрбум мод төслийн хүрээнд 6,300 орчим мод тарьж, байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээгээр 15,000.0 мянган төгрөг төсөвлөж гүйцэтгэлээр 12,550.0 мянган төгрөг зарцуулж тогтмол усалгаа арчилгаа хийж ажилласан байна. ОНХС-ийн хөрөнгөөр жижиг гүүр засварлах, сумын төвийн цахилгаан эрчим хүчний шонг 85,455.9 мянган төгрөгөөр шинэчлэх, сумын төвийн камер нэмэгдүүлэх, багийн Засаг дарга нарт суудлын автомашин 28,900.0 мянган төгрөг, төрийн албан хаагчдын компьютер тоног төхөөрөмжийг шинэчлэх гэх мэт ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

4176020132

Бусад асуудлын хэсэг

Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг даргын Тамгын газар нь гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилт, 26 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн хэрэгжүүлж, гүйцэтгэлээр 90,0 хувийн биелэлттэй байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	230,695,342.78	226,421,545.32
33	АВЛАГА	45,000.00	45,000.00
335	Бусад авлага	45,000.00	45,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	45,000.00	45,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	230,650,342.78	226,376,545.32
351	Түүхий эд материал	25,243,250.00	26,093,237.00
35110	Тусгай зориулалттай материал	25,243,250.00	26,093,237.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	30,694,000.00	12,665,000.00
354	Хангамжийн материал	101,473,092.78	109,408,308.34
35410	Бичиг хэргийн материал	5,045,100.00	5,371,820.00
35420	Аж ахуйн материал	60,323,903.90	67,932,403.90
35430	Сэлбэг хэрэгсэл	21,095,000.00	21,095,000.00
35440	Түлш, шатах тослох материал	4.44	-
35450	Барилгын засварын материал	3,345,000.00	3,345,000.00
35470	Бусад хангамжийн материал	11,664,084.44	11,664,084.44
35500	Биологийн хөрөнгө	7,720,000.00	12,820,000.00
35600	Мал амьтад	65,520,000.00	65,389,999.98
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,146,339,715.91	2,163,372,141.51
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,146,339,715.91	2,163,372,141.51
392	Биет хөрөнгө	1,958,709,695.91	1,975,742,121.51
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,662,488,716.00	1,729,388,833.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(276,848,432.66)	(388,403,015.24)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	550,472,835.00	517,825,116.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(212,460,227.11)	(180,647,264.26)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	136,063,350.00	168,560,620.93
39206	Хуримтлагдсан элэгдэл	(73,037,195.75)	(64,505,868.56)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	21,230,542.30	26,522,197.80
39208	Хуримтлагдсан элэгдэл	(13,712,499.15)	(10,424,693.87)
39209	Зам, гүүрийн байгууламж	98,756,054.00	124,728,054.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(20,878,667.80)	(22,555,618.54)
39214	Бусад үндсэн хөрөнгө	261,957,192.00	261,957,192.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(175,321,970.92)	(186,703,431.75)
393	Биет бус хөрөнгө	187,630,020.00	187,630,020.00
39301	Програм хангамж	22,135,100.00	22,135,100.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,549,080.00)	(1,549,080.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	167,044,000.00	167,044,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,377,035,058.69	2,389,793,686.83
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,106,966.38	17,994,801.70
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,106,966.38	17,994,801.70
413	Өглөг	1,106,966.38	17,994,801.70
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	26,966.38	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,080,000.00	3,430,000.00
4136	Бусад өглөг	-	14,564,801.70
41361	Байгууллагад төлөх өглөг	-	14,564,801.70

5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,375,928,092.31	2,371,798,885.13
51	Засгийн газрын хувь оролцоо	2,375,928,092.31	2,371,798,885.13
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	425,137,525.38	425,137,525.38
51101	Өмч: - төрийн	425,137,525.38	425,137,525.38
512	Хуримтлагдсан үр дүн	1,753,278,909.80	1,749,149,702.62
51210	Өмнөх үеийн үр дүн	1,753,278,909.80	1,753,278,909.80
51220	Тайлант үеийн үр дүн	-	(4,129,207.18)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	197,511,657.13	197,511,657.13
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,377,035,058.69	2,389,793,686.83

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,316,601,743.69	1,044,340,707.19
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,316,601,743.69	1,044,340,707.19
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	330,408,243.69	119,825,807.19
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	15,820,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	266,021,849.50	87,937,898.50
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	48,566,394.19	31,887,908.69
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	986,193,500.00	924,514,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	986,193,500.00	924,514,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,438,097,714.22	1,208,535,614.53
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,257,018,687.32	1,160,311,275.53
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,133,193,656.11	1,078,907,232.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	583,310,400.97	688,945,312.88
210101	Үндсэн цалин	329,971,850.08	388,511,485.70
210102	Нэмэгдэл	234,070,313.40	285,220,501.68
210104	Урамшуулал	15,595,280.29	15,213,325.50
210105	Гэрээт ажлын хөлс	3,672,957.20	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	72,177,567.83	85,404,768.26
210201	Тэтгэврийн даатгал	49,832,748.81	58,744,104.68
210202	Тэтгэмжийн даатгал	5,796,772.62	6,878,450.18
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,895,086.31	3,429,325.08
210204	Ажилгүйдлийн даатгал	2,703,739.46	3,260,313.66
210205	Эрүүл мэндийн даатгал	10,949,220.63	13,092,574.66
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,836,753.50	38,513,493.33
210301	Гэрэл, цахилгаан	6,908,753.50	7,625,493.33
210302	Түлш, халаалт	26,928,000.00	30,888,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	136,348,127.16	53,028,736.46
210401	Бичиг хэрэг	2,327,000.00	2,784,680.00
210402	Тээвэр, шатахуун	50,676,384.31	16,761,856.44
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,382,500.00	5,072,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	100,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	77,962,242.85	28,310,000.02
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,547,000.00	1,487,000.00
210604	Урсгал засвар	14,547,000.00	1,487,000.00
2107	Томилолт, зочны зардал	13,524,000.00	12,720,000.00
210702	Дотоод албан томилолт	13,524,000.00	12,720,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,287,331.00	3,621,146.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,316,544.00	2,324,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	231,120.00	650,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	731,667.00	154,918.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	250,000.00
210807	Газрын төлбөр	-	242,228.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	272,162,475.65	195,186,775.33
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	135,748,710.00	32,497,290.00

210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	136,413,765.65	162,689,485.33
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	123,825,031.21	81,404,043.27
2132	Бусад урсгал шилжүүлэг	37,161,741.51	51,984,091.27
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	5,815,482.01	47,701,691.27
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	29,346,259.50	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	4,282,400.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	86,663,289.70	29,419,952.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	86,663,289.70	29,419,952.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	181,079,026.90	48,224,339.00
2200	Дотоод эх үүсвэрээр	181,079,026.90	48,224,339.00
221001	Их засвар	181,079,026.90	48,224,339.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(121,495,970.53)	(164,194,907.34)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(121,495,970.53)	(164,194,907.34)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,316,601,743.69	1,044,340,707.19
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,316,601,743.69	1,044,340,707.19
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	330,408,243.69	119,825,807.19
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	15,820,000.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	266,021,849.50	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	48,566,394.19	87,937,898.50
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	31,887,908.69
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	986,193,500.00	924,514,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	986,193,500.00	924,514,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	995,515,885.86	977,128,972.12
21	УРСГАЛ ЗАРДАЛ	995,515,885.86	977,128,972.12
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	871,690,854.66	895,474,928.85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	583,310,400.98	688,945,312.88
210101	Үндсэн цалин	329,971,850.08	388,511,485.70
210102	Нэмэгдэл	234,070,313.40	285,220,501.68
210104	Урамшуулал	15,595,280.29	15,213,325.50
210105	Гэрээт ажлын хөлс	3,672,957.21	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	72,150,601.45	85,431,734.64
210201	Тэтгэврийн даатгал	49,805,782.43	58,771,070.06
210202	Тэтгэмжийн даатгал	5,796,772.62	6,878,450.18
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,895,086.31	3,429,325.08
210204	Ажилгүйдлийн даатгал	2,703,739.46	3,260,313.66
210205	Эрүүл мэндийн даатгал	10,949,220.63	13,092,575.66
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,836,753.53	38,513,493.33
210301	Гэрэл, цахилгаан	6,908,753.53	7,625,493.33
210302	Түлш, халаалт	26,928,000.00	30,888,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	41,517,442.70	21,190,854.00
210401	Бичиг хэрэг	2,350,000.00	3,046,900.00
210402	Тээвэр, шатахуун	33,669,942.70	12,966,254.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,197,500.00	5,077,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	100,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	300,000.00	-
2105	Нормативт зардал	850,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	850,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,544,000.00	4,959,500.00
210604	Урсгал засвар	21,544,000.00	4,959,500.00
2107	Томилолт, зочны зардал	12,444,000.00	10,370,000.00
210702	Дотоод албан томилолт	12,444,000.00	10,370,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,139,726.00	3,621,146.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,168,939.00	2,324,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	231,120.00	650,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	621,667.00	154,918.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	110,000.00	250,000.00

210807	Газрын төлбөр	-	242,228.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	93,897,930.00	42,442,888.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	93,897,930.00	42,442,888.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	123,825,031.20	81,654,043.27
2132	Бусад урсгал шилжүүлэг	37,161,741.50	52,234,091.27
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	5,815,482.00	47,701,691.27
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	29,346,259.50	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	4,532,400.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	86,663,289.70	29,419,952.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	86,663,289.70	29,419,952.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	321,085,857.83	67,211,735.07
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	312,122,975.80	43,007,024.30
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	312,122,975.80	43,007,024.30
2200	Дотоод эх үүсвэрээр	312,122,975.80	43,007,024.30
221001	Их засвар	82,766,576.00	34,607,024.30
223001	Бусад хөрөнгө	121,791,132.80	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	107,565,267.00	8,400,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(312,122,975.80)	(43,007,024.30)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	8,962,882.03	24,204,710.77
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	930,302,209.41	930,302,209.41
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	930,302,209.41	930,302,209.41
D01	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	930,302,209.41	930,302,209.41
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	930,302,209.41	930,302,209.41
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(4,129,207.18)	(4,129,207.18)
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	926,173,002.23	926,173,002.23

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	95,621,096.42
21	УРСГАЛ ЗАРДАЛ	95,621,096.42
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	95,621,096.42
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	76,449,600.19
210102	Нэмэгдэл	75,935,299.69
210104	Урамшуулал	514,300.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,454,856.23
210201	Тэтгэврийн даатгал	6,513,668.06
210202	Тэтгэмжийн даатгал	759,353.03
210203	ҮОМШӨ-ний даатгал	379,676.54
210204	Ажилгүйдлийн даатгал	360,431.54

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

Аудитаар нийт 91,435.2 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

1. Санхүүгийн үр дүнгийн тайлан болон мөнгөн гүйлгээний тайланд төвлөрүүлэх шилжүүлэг 53,624.7 мянган төгрөгийг салгаж тайлагнаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “ангилал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2. Сангийн сайдын А/3 дугаар тушаалын хавсралтын дагуу тайлагнаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3. Төсвийн гүйцэтгэлийн тайланд тайлант оны батлагдсан төлөвлөгөөг тайлагнаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4. Санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалыг бараа материалын тодруулга тайланд 10,578.5 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5. Санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийг үндсэн хөрөнгийн тодруулга тайланд 27,232.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “үнэлээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Залруулагдаагүй нийт 21,717.2 мянган төгрөгийн зөрчлөөс 3,722.4 мянган төгрөгийн материаллаг зөрчил нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшнээс 11,460.4 мянган төгрөгөөр бага тул “**Өөрчлөлтгүй**” дүгнэлт өгсөн.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Аудитаар нийт 21,717.2 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 3,722.4 мянган төгрөгийн 1 албан шаардлага өгч, 17,994.8 мянган төгрөгийн 1 зөвлөмж хүргүүллээ.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

5.2 Албан шаардлага

1. Тайлант онд зохион байгуулсан Гамшгаас хамгаалах команд штабын сургуульд сумын Гамшгаас хамгаалах шуурхай штабыг удирдан зохион байгуулсан Засаг дарга болон ЗДТГ-н даргад нэг сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн шагнал болох 3,722.4 мянган төгрөгийг олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-д “Хуулиар зөвшөөрөөгүй бусад”, 15.1.3-т “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэж заасныг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.3-д “цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Өр төлбөр данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тус байгууллага нь тайлант онд ажиллагсадтай холбогдсон албан томилолтын өглөг 3,430.0 мянган төгрөг, байгууллагад төлөх өглөг 14,564.8 мянган төгрөг нийт 17,994.8 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” заалтыг болон санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Цаашид төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2026 оны 03 дугаар сарын 25-ны дотор, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 10 -ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган
төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант онд зохион байгуулсан Гамшгаас хамгаалах команд штабын сургуульд сумын Гамшгаас хамгаалах шуурхай штабыг удирдан зохион байгуулсан Засаг дарга болон ЗДТГ-н даргад нэг сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн шагнал болох 3,722.4 мянган төгрөгийг олгосон байна.	1				1	3,722.4		
Тус байгууллага нь тайлант онд ажиллагсадтай холбогдсон өглөг албан томилолтын өглөг 3,430.0 мянган төгрөг, байгууллагад төлөх өглөг 14,564.8 мянган төгрөг нийт 17,994.8 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн байна.	1	17,994.8					1	17,994.8
Дүн	2	21,717.2			1	3,722.4	1	17,994.8

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn